



**ҮНДЭСНИЙ
БАЯЛГИЙН САН**

ОЛОН УЛС ДАХЬ ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ХОЛБООД, НИЙГЭМЛЭГ, ХАМТЫН АЖИЛЛАГАА

Судалгаа №: ҮБС-004/008002/2025

2025 он

Агуулга

Товчилсон нэр томъёо	3
ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ХОЛБОО, НИЙГЭМЛЭГ, СҮЛЖЭЭ БАЙГУУЛЛАГУУДЫН СУДАЛГАА	4
1. Судалгааны тухай	4
2. Судалгааны дүгнэлт	4
3. ОЛОН УЛСЫН БАЯЛГИЙН САНГУУДЫН НИЙГЭМЛЭГ (SWFI)	6
3.1 Товч танилцуулга	6
3.2 Гишүүнчлэл	7
3.3 Дэлхийн баялгийн сангийн чуулган	7
3.4 Линабург-Мадзуэллын индекс (Linaburg–Maduell Transparency Index-LMTI)	8
4. ОЛОН УЛСЫН ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГУУДЫН ФОРУМ (INTERNATIONAL FORUM OF SOVEREIGN WEALTH FUNDS - IFSWF)	9
4.1 Товч танилцуулга	9
4.2 Гишүүнчлэл	11
4.3 Форумын жилийн чуулган	15
4.4 Сантьяго зарчмуудын тухай	16
5. НЭГ ДЭЛХИЙ ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГУУДЫН СҮЛЖЭЭ (ONE PLANET SWF)	20
5.1 Товч танилцуулга	20
5.2 Гишүүнчлэл	21
5.3 Нэг дэлхий ҮБС-гуудын зарчим	22
5.4 Сүлжээний жилийн чуулга уулзалт	24
6. Нэмэлт судалгаа: ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГУУДЫН СУДАЛГААНЫ ТӨВ (GLOBAL SWF, Global Sovereign Reserve Network GSRN)	25
6.1 Товч танилцуулга	25
6.2 Засаглал, Тогтвортой байдал ба Тэсвэрлэх чадварын үнэлгээ (Governance, Sustainability and Resilience - GSR-Scoreboard)	26
7. Нэмэлт судалгаа: ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН (INTERNATIONAL MONETARY FUND - IMF)	28
7.1 Товч танилцуулга	28
7.2 Гол ажлууд	29

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Нийгэмлэгийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн	6
Хүснэгт 2. Гишүүнчлэлийн мэдээлэл	7
Хүснэгт 3. Индексийн 10 үзүүлэлт	8
Хүснэгт 4. Форумын ТУЗ-ийн бүрэлдэхүүн	10
Хүснэгт 5. Форумын гол үйл явдал, он цагийн дараалал	10
Хүснэгт 6. Форумын гишүүнчлэл	11
Хүснэгт 7 . Гишүүнчлэлээс гарсан ҮБС-гууд	12
Хүснэгт 8. Форумын одоогийн гишүүн ҮБС	13
Хүснэгт 9. Форумын сүүлийн 10 удаагийн жилийн уулзалтууд	15
Хүснэгт 10. Сантьяго зарчмууд	17
Хүснэгт 11. Гол үйл явдлууд	20
Хүснэгт 12. Сүлжээний гишүүн ҮБС	22
Хүснэгт 13. Зарчмуудын дэлгэрэнгүй	23
Хүснэгт 14. Сүлжээний чуулга уулзалт	24
Хүснэгт 15. Төвийн гол түүхэн үйл явдал	25
Хүснэгт 16. Үнэлгээ	26
Хүснэгт 17. ОУВС-аас ҮБС-гуудтай холбоотой авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээ,	28
Хүснэгт 18. ОУВС-аас ҮБС холбоотой гаргасан сэдэвт судалгаа, нийтлэл	29

Товчилсон нэр томъёо

Товчлол	Тайлбар
Монгол хэл дээр	
АНЭУ	Арабын Нэгдсэн Эмират Улс
БОНЗ	Байгаль орчин, нийгэм, засаглал
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ҮБС	Үндэсний баялгийн сан
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
ОУВС	Олон Улсын Валютын Сан
БОНЗ	Байгаль орчин, Нийгэм, Засаглал
Англи хэл дээр	
API	Application Programming Interface
ADIA	Abu Dhabi Investment Authority
CIC	China Investment Corporation
GPFG	Government Pension Fund Global (Norway)
GWC	Global Wealth Conference
IWG-SWF	International Working Group of Sovereign Wealth Funds
KIA	Kuwait Investment Authority
NZSF	New Zealand Superannuation Fund
QIA	Qatar Investment Authority
PIF	Public Investment Fund (Saudi Arabia)
SWFI	Sovereign Wealth Fund Institute

ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГИЙН ХОЛБОО, НИЙГЭМЛЭГ, СҮЛЖЭЭ БАЙГУУЛЛАГУУДЫН СУДАЛГАА

1. Судалгааны тухай

Монгол Улсын Чингис хаан Үндэсний баялгийн санг олон улсад таниулах болон олон улсын хамтын ажиллагаа эрчимтэй эхлүүлж буй энэ үед салбарын тэргүүлэгч холбоод, идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж буй холбогдох талуудтай холбоо тогтоож, нэгдэл холбоодод гишүүнээр элссэнээр олон улсын түвшинд итгэлцэл бий болгох, баялгийн сангуудтай харилцан туршлага солилцох, баялгийн сан, санхүүгийн салбарын нэр хүндтэй оролцогч болох ач холбогдолтой юм. Ялангуяа Олон улсын үндэсний баялгийн сангуудын форум болон Нэг дэлхий үндэсний баялгийн сангуудын сүлжээ зэрэг байгууллагууд нь сангийн засаглал, уур амьсгалын нөлөө бүхий хөрөнгө оруулалтын бодлогыг хөгжүүлэхэд мэргэжлийн болон техникийн дэмжлэг үзүүлэх боломжтой. Мөн түүнчлэн Үндэсний баялгийн сангуудын нийгэмлэг зэрэг мэдээллийн платформуудыг идэвхтэй ашиглах, Дэлхийн баялгийн сангийн чуулган зэрэг томоохон арга хэмжээнд идэвхтэй оролцох нь ил тод байдал, олон нийтийн ойлголтыг бэхжүүлэх, гадаад хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх чухал хөшүүрэг болно гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын ҮБС-ийн гадаад хамтын ажиллагааны стратегийг тодорхойлох, гишүүнчлэлийн зорилтот платформуудыг үе шаттайгаар тодорхойлж, шаардлагатай бэлтгэл арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэхэд дэмжлэг болгох үүднээс энэхүү судалгааг боловсруулав.

Судалгаанд дараах үндсэн платформ, сүлжээ, байгууллагуудын талаар мэдээллийг хамруулсан болно. Үүнд:

- Олон улсын Үндэсний баялгийн сангуудын нийгэмлэг (Sovereign Wealth Fund Institute -SWFI)
- Олон улсын Үндэсний баялгийн сангуудын форум (International Forum of Sovereign Wealth Funds- IFSWF)
- Нэг дэлхий Үндэсний баялгийн сангуудын сүлжээ (One Planet Sovereign Wealth Funds-OPSWF)
- Нэмэлтээр салбарын хөгжилд хувь нэмэр оруулж буй Үндэсний баялгийн сангуудын судалгааны төв (Global SWF), Олон улсын валютын сан (International Monetary Fund)-ийн талаар мэдээллийг багтаав.

2. Судалгааны дүгнэлт

Дэлхий дахинд Үндэсний баялгийн сангууд (ҮБС)-ийн тоо, удирдаж буй хөрөнгийн хэмжээ өсөн нэмэгдэж буй хэрээр олон улсад ҮБС-гуудын хамтын ажиллагаа, бодлого төлөвлөлт, засаглал, уур амьсгалын өөрчлөлт, БОНЗ-ын зарчим, ил тод байдал, өгөгдлийн нээлттэй байдал зэрэг асуудлаар хамтран ажиллах IFSWF, OPSWF, SWFI, Global SWF зэрэг байгууллага, платформууд

бүрэлдэн тогтжээ. Эдгээр сүлжээ, платформ бүр өөр өөрийн тодорхой чиг үүрэгтэй бөгөөд ач холбогдолтой юм. Тухайлбал:

1. Олон улсын ҮБС-гуудын шилдэг жишиг, зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх уриалдаг ашгийн бус байгууллага

- IFSWF нь Сантьягогийн зарчмыг хэрэгжүүлэх, засаглалын хариуцлага, ил тод байдлыг дэмжих зорилготой бөгөөд ҮБС-уудын гол бодлогын форумын үүрэг гүйцэтгэдэг. Одоогоор 43 гишүүн ҮБС-гуудаас бүрддэг.
- OPSWF нь Парисын хэлэлцээртэй уялдуулан уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд чиглэсэн урт хугацааны хөрөнгө удирдлагыг дэмждэг стратегийн хамтын ажиллагааны нэгдэл юм. Тэргүүлэгч 18 ҮБС-гууд гишүүнчлэлд багтдаг, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй сүлжээ.

2. Мэргэжлийн хувийн хэвшлийн хамтын ажиллагааны платформ, судалгаа шинжилгээний мэдээллийн сан

- Үүнээс SWFI-аас зохион байгуулдаг Global Wealth Conference нь дэлхийн баялгийн сан, тэтгэврийн сан, хөрөнгө удирдлагын мэргэжилтнүүдийг холбосон жил бүрийн томоохон чуулганг зохион байгуулдаг бөгөөд сүүлийн жилүүдэд хувийн хөрөнгө оруулалт, инновац, хөгжиж буй зах зээл зэрэг сэдвүүдийг түлхүү хэлэлцэж байна.
- Global SWF нь өгөгдөл, судалгаа, ил тод байдлын индексүүдээр дамжуулан олон нийт болон хөрөнгө оруулагч нарт мэдээлэл түгээж, харьцуулсан үнэлгээ хийдэг байгууллага юм.

Чингис хаан Үндэсний баялгийн сангийн хувьд, олон улсад танигдах үйл ажиллагааг SWFI-ийн жилийн дээд хэмжээний уулзалт буюу Лондон хотноо 2025 оны 6 дугаар сарын 17-19 өдрүүдэд зохион байгуулагдсан “Дэлхийн баялгийн сангийн чуулга уулзалт” арга хэмжээнд оролцсоноор ҮБС-гуудын эгнээнд нэгдэж, гишүүнчлэлийн төлбөрөөс 3 жил чөлөөлөгдөж, олон улсын хамтын ажиллагааг амжилттай эхлүүлсэн.

Цаашид үргэлжлүүлэн IFSWF-д Ирээдүйн өв сан нь харилцагч гишүүний статустай хэвээр эсэхийг баталгаажуулах¹, баталгаажуулсны үндсэн дээр Үндэсний баялгийн сан болон төрөлжсөн бусад сангуудыг бүртгүүлэх, гишүүн ҮБС-гуудаас харилцан туршлага солилцох хөтөлбөрүүдэд хамрагдах, сангийн үйл ажиллагаанд Сантьяго зарчмыг бүрэн нэвтрүүлэх зэрэг давуу талтай гэж үзэж байна.

¹ 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр АНУ-ын Аляска мужид зохион байгуулсан Форумын жилийн уулзалтын үеэр Монгол Улсын Ирээдүйн өв санг “Харилцагч гишүүн”-ээр элссэн тухай зарласан байдаг. Гэсэн хэдий Ирээдүйн өв сангийн мэдээлэл Форумын харилцагч гишүүдийн жагсаалтад байхгүй байгаагаас үзэхэд өнөөдрийн байдлаар харилцагч гишүүний статус хүчинтэй эсэх нь тодорхой бус, гишүүнчлэлийн статусыг баталгаажуулах шаардлагатай гэж дүгнэхэд хүргэж байна.

Чингис хаан Үндэсний баялгийн сангийн хувьд сангийн засаглал, үйл ажиллагааны суурийг бэхжүүлэхэд OPSWF-ийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг урт хугацааны хөрөнгө удирдлагын зарчмуудыг үе шаттай нэвтрүүлэх талаар харгалзан үзэж, улмаар OPSWF-д нэгдэх боломж бүрдэнэ гэж дүгнэж байна.

3. ОЛОН УЛСЫН БАЯЛГИЙН САНГУУДЫН НИЙГЭМЛЭГ (SWFI)

3.1 Товч танилцуулга

Олон улсын баялгийн сангуудын нийгэмлэг (цаашид “Нийгэмлэг” гэх) нь баялгийн сангууд, төв банк, тэтгэврийн сан болон бусад институцийн хөрөнгө оруулагчдад зориулсан судалгаа, өгөгдөл, зөвлөх үйлчилгээ болон стратегийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулдаг бие даасан, олон улсын байгууллага юм. 2008 онд АНУ-д байгуулагдсан, Невада мужид бүртгэлтэй тус нийгэмлэг нь нийт \$10 их наяд ам.доллараас давсан хөрөнгийг удирддаг 100+ хөрөнгө оруулагч байгууллагуудыг хамардаг.

Нийгэмлэгийн үндсэн үйл ажиллагаа:

- Судалгаа шинжилгээ, мэдээллийн томоохон сан: баялгийн сан, институцийн хөрөнгө оруулагчдын танилцуулга, удирддаг хөрөнгө, хийсэн хэлцэл, зах зээлийн үнэлгээ, тайлан зэрэг мэдээллийн сан.
- SWFI Markets: хөрөнгө оруулагч нарт тайлан, санхүүгийн мэдээллийг боловсруулж, дүн шинжилгээ хийх нэгдсэн платформ
- SWFI Quarterly: Олон улсын хөрөнгө оруулалт, зах зээлийн шинжлэх ухааны сэтгүүл
- Баялгийн форум, хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, сургалт, арга хэмжээ.
- ҮБС-гуудын ил тод байдлыг үнэлдэг Линабург-Мадуэллын ил тод байдлын индексийг тооцоолж, нийтэлдэг.

Хүснэгт 1. Нийгэмлэгийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Нэр	Албан тушаал / Үүрэг	Тайлбар
Lakshmi Narayanan	ТУЗ-ийн дарга	Patel Family Office байгууллагын ТУЗ-ийн гишүүн, захирлаар ажилладаг.
Michael Maduell	ТУЗ-ийн гишүүн	Нийгэмлэгийн Ерөнхийлөгч, Гүйцэтгэх захирал бөгөөд үүсгэн байгуулагч
Kim S. Diamond	ТУЗ-ийн гишүүн	S&P Global-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.
Dipika Patel	ТУЗ-ийн гишүүн	Hayden Holdings-ийн Гүйцэтгэх захирал, Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан.

Эх сурвалж: Нийгэмлэгийн цахим хуудас

3.2 Гишүүнчлэл

Байгууллагууд болон хувь хүмүүс гишүүнчлэлийн хүсэлт гаргасны үндсэн дээр нэг жилийн хугацаатай гишүүнчлэлийн эрх авдаг.

Хүснэгт 2. Гишүүнчлэлийн мэдээлэл

Төрөл	Гишүүнчлэлийн төлбөр	Давуу тал
Sapphire (хувь хүн)	\$15,000/жил	Нийгэмлэгээс зохион байгуулж буй 2 VIP урилгын эрх, SWFI Markets, Quarterly хөтөлбөр
Emerald (байгууллага)	\$15,000–\$10,000/нэмэлт	Нийгэмлэгээс зохион байгуулж буй 3 арга хэмжээнд оролцох эрх, Quarterly, мэдээлэл
Ruby (стартап)	\$10,000/жил	2 арга хэмжээнд нэг тасалбар, SWFI Markets

Эх үүсвэр: Нийгэмлэгийн цахим хуудас

Гишүүнчлэлд элссэнээр дараах давуу талуудыг хүлээн авах боломжтой. Үүнд:

- Баялгийн удирдлагын салбарын түүчээлэгчдийн мэргэжлийн платформ: Баялгийн удирдлага хэрэгжүүлдэг байгууллагууд мэдээ мэдээллээ дэлхийд түгээх боломж, баялгийн салбарын томоохон VIP буюу зөвхөн урилгын дагуу арга хэмжээнд оролцох (SWF Summit, Global Wealth Conference), нетворкинг хийх, хамтын ажиллагаа эхлүүлэх.
- Эдийн засаг, баялгийн удирдлагын талаар цаг үеийн шинэлэг мэдээ, мэдээлэл хүлээн авах (SWFI Markets платформ, SWF Quarterly сэтгүүл),
- Нээлттэй платформоор дамжуулан бизнесийн судалгаа, API² өгөгдөл ашиглан холболт хийх.
- Гишүүн байгууллагыг олон улсын түвшинд болон хэвлэл мэдээлэлд нэр заагдан таниулан, сурталчлах.

3.3 Дэлхийн баялгийн сангийн чуулган

Дэлхийн баялгийн сангийн чуулган буюу “Global Wealth Conference” (GWC) нь Нийгэмлэг болон Их Британи, Умард Ирландын Вант Улсын нийслэл Лондон хотын хамтарсан, олон улсын хөрөнгө оруулалт, мөнгөний менежментийн чиглэлээр салбарын хамгийн өндөр түвшний удирдагчдыг нэг дор нэгтгэн чуулдаг, “баялгийг сайн, зөв, үр дүнтэй хэрэгцээнд нь чиглүүлэх” бодлогыг уриалсан платформ бөгөөд жил бүрийн 5-6 саруудад зохион байгуулагддаг арга хэмжээ юм.

2025 оны ээлжит чуулган Лондон хотноо 2025 оны 6 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд болж, тус арга хэмжээнд Монгол Улсын Үндэсний баялгийн сан анх удаа оролцож, Чингис хаан Үндэсний баялгийн сан ХХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Тэмүүлэн “Funding the Future: Investors powering the Tech Revolution” сэдэвт

² Application Programming Interface буюу програм хангамжийн холболтын интерфэйс

салбар хэлэлцүүлгийн панелистаар уригдан оролцлоо. Энэхүү оролцоогоороо дамжуулан Нийгэмлэгийн удирдлагууд, АНУ-ын Фючерс зохицуулах хороо, GIC, Mubadala, Qatar Investment Authority, Abu Dhabi Investment Authority, LAZARD зэрэг дэлхийн тэргүүлэх баялгийн сангууд болон хөрөнгө удирдлагын байгууллагуудтай танилцан, харилцан хамтын ажиллагааны суурь ойлголцолд хүрч, Чингис хаан Үндэсний баялгийн санд гишүүнээр элсэх эрх олгосон.

3.4 Линабург-Мадуэллын индекс (Linaburg–Maduell Transparency Index-LMTI)

Linaburg–Maduell Transparency Index нь 2008 онд Нийгэмлэгийн үүсгэн байгуулагч Карл Линабург (Carl Linaburg) болон Майкл Мадуелл (Michael Maduell) нарын бүтээл бөгөөд дэлхийн ҮБС-гуудын ил тод байдлыг үнэлэх үзүүлэлт тус бүр 1 оноотой нийт 10 үзүүлэлтээр үнэлдэг индекс юм. Индексээс олгодог хамгийн бага боломжит оноо нь 1 бөгөөд тухайн сан 8 болон түүнээс дээш оноо авч байж ил тод ҮБС-д тооцогддог.

Хүснэгт 3. Индексийн 10 үзүүлэлт

Оноо	Ил тод байдлын шалгуур үзүүлэлт (зарчим)
+1	Сангийн түүх, байгуулсан зорилго, эх үүсвэр, эрх зүйн үндэслэл, засгийн газрын оролцооны тайлбарыг агуулсан байх.
+1	Бие даасан аудитын байгууллагаар баталгаажуулсан жилийн тайлан нийтэлдэг, мэдээллийг шинэчилдэг байх.
+1	Сангийн хөрөнгийн бүтэц, хувь оролцоот компани, хөрөнгийн байршлыг тайлбарласан байх.
+1	Сангийн удирддаг хөрөнгийн зах зээлийн үнэлгээ, хөрөнгө оруулалтын өгөөж, удирдлагын цалин урамшууллын мэдээлэлтэй байх.
+1	Ёс зүй, засаглал, хөрөнгө удирдлагын бодлого, эрсдэлийн удирдлагын журамтай байх.
+1	Сангийн алсын хараа, стратеги зорилго тодорхой, нийтэд ил тод нийтэлсэн байх.
+1	Холбоотой охин компаниудын мэдээлэл, менежментийн бүтэц, хамааралтай байгууллагын холбоо барих мэдээллийг нийтэлсэн байх.
+1	Хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэхэд гаднын байгууллага оролцдог бол мэдээлэл ил тод байх.
+1	Сангийн удирдлагыг хэрэгжүүлэгч албан ёсны вебсайттай, түүн дээр холбогдох мэдээллээ тогтмол шинэчилдэг байх.
+1	Офисын байршил, хаяг, утас, факс зэрэг холбоо барих мэдээлэл олон нийтэд нээлттэй байх

Эх сурвалж: Нийгэмлэгийн цахим хуудас³

Энэхүү индексийг ҮБС-гууд ил тод байдлаа нэмэгдүүлэх, өөрсдийн тайлан мэдээллийн нэг хэсэг болгон ашиглаж эхэлжээ. Уг индекс нь ил тод байдлыг хэмжих,

³ [Линабург-Мадуэллын ил тод байдлын индекс](#)

дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн, практик хэрэглээнд өргөн хэрэглэгддэг хэрэгсэл төдийгүй улс орны засаглалын чанар, сангийн хөрөнгө оруулалтын зан төлөв зэрэг хүчин зүйлүүдтэй уялдаатай байдлыг үнэлж дүгнэдэгт ач холбогдолтой юм

4. ОЛОН УЛСЫН ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГУУДЫН ФОРУМ (INTERNATIONAL FORUM OF SOVEREIGN WEALTH FUNDS - IFSWF)

4.1 Товч танилцуулга

Дэлхийд амжилттай үйл ажиллагаагаа явуулж буй, сайн туршлага гэж хүлээн зөвшөөрөгдсөн ҮБС-гууд Олон улсын үндэсний баялгийн сангуудын форум (цаашид “Форум” гэх)-д гишүүнээр элссэн байдаг. Энэхүү форум нь 2009 онд ОУБС-ын дэмжлэгтэй байгуулагдсан, одоогоор 38 бүрэн эрхт гишүүн, 5 харилцагч гишүүн ҮБС-уудын гишүүнчлэлтэй бөгөөд гишүүн ҮБС-гууд нь Сантьягогийн зарчмуудыг мөрдөнө гэсэн шаардлагын дагуу сайн дурын үндсэн дээр элсдэг. Форумын гишүүн болсноор баялгийн сангууд нь тогтмол Сантьягогийн зарчмуудыг мөрдөж буй талаар тогтмол давтамжтай (3 жил) бие даан үнэлгээ хийж, Форумд тайлангаа хүргүүлдэг.

Форумын үйл ажиллагааны гол зорилго нь:

- Сантьягогийн зарчмуудыг хэрэгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх,
- Гишүүн ҮБС-гууд хооронд туршлага, мэдээлэл солилцох, хамтын ажиллагааг дэмжих,
- Ил тод байдал, засаглал, хариуцлагын жишиг тогтоох,
- Баялгийн сангуудын тухай олон нийтийн ойлголт, итгэлийг нэмэгдүүлэхэд оршдог.

Форумын өдөр тутмын үйл ажиллагааг хариуцсан ажлын алба Лондон хотод байрлах ба гишүүн ҮБС-гууд биечлэн болон цахим хэлбэрээр уулзалт, арга хэмжээг зохион байгуулах, судалгааны ажлыг гүйцэтгэдэг дэд хороодыг хуралдуулах, гишүүд хоорондын харилцан туршлага солилцох төслүүдийг хэрэгжүүлэх болон Форумын жилийн уулзалтын зохион байгуулах зэрэг ажлуудыг хариуцан гүйцэтгэдэг.

Форумын удирдах байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл бөгөөд Форумын гишүүн орнууд 3 жилийн хугацаатай Дарга, Дэд дарга болон 3 гишүүн нийт 5 гишүүний бүрэлдэхүүнтэй зөвлөлийг сонгож, ТУЗ нь Форумын стратегийн удирдлагаар хангаж, Форумын Гүйцэтгэх захирлыг томилдог. Форум байгуулагдсан цагаас хойш ТУЗ-ийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын СІС-аас тогтмол сонгогдож ажиллаж байсан.

Хүснэгт 44. Форумын ТУЗ-ийн бүрэлдэхүүн

Нэр	Форумын ТУЗ	Албан тушаал	Байгууллага
Obaid Amrane	Нарийн бичиг	Гүйцэтгэх захирал	Ithmar Capital, Марокко
Dhaen Al Hameli	ТУЗ-ийн дарга	Гүйцэтгэх захирал	ADIA – Abu Dhabi Investment Authority
Israfil Mammadov	Дэд дарга	Гүйцэтгэх захирал	SOFAZ – State Oil Fund of Azerbaijan
WONG Ai Chiat	Гишүүн	Засаглал, харилцагч, үйл ажиллагаа хариуцсан газрын дарга	GIC Private Limited, Сингапур
LIU Haoling	Гишүүн	ТУЗ-ийн дэд дарга, Ерөнхийлөгч бөгөөд Хөрөнгө оруулалт хариуцсан захирал	CIC – China Investment Corporation
Will Hetherton	Гишүүн	Корпорацийн харилцаа холбоо, үйл ажиллагаа хариуцсан захирал	Future Fund, Австрали

Эх сурвалж: Форумын цахим хуудас

Форум нь 2009 оны 4 дүгээр сард Сантьягогийн зарчмуудыг боловсруулсан олон улсын ажлын хэсэг (IWG-SWF)-ийн үргэлжлэл болж Кувейт хотноо “Kuwait Declaration” дүгнэлтээр байгуулагдаж, эхний жилүүдэд ОУВС-ын дэмжлэг авч байсан бол, 2014 онд Лондонд бие даасан Ажлын алба байгуулсан цагаас ҮБС-гуудын бие даасан форум болон хөгжиж, түүнээс хойш сургалт, судалгаа, БОНЗ, гишүүд хооронд харилцан туршлага солилцох хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлсээр ирсэн.

Хүснэгт 5. Форумын гол үйл явдал, он цагийн дараалал

Он	Үйл явдал	Тайлбар
2008 оны 4 дүгээр сар	IWG байгуулсан	ОУВС-ын дэмжлэгтэйгээр “ Sovereign Wealth Fund Working Group ” буюу 26 орны баялгийн сангийн бүрэлдэхүүн бүхий ажлын хэсэг байгуулагдсан.
2008 оны 10 дугаар сар	Сантьягогийн зарчмууд	Тус ажлын хэсэг нь Чилийн Сантьяго хотноо уулзалт хийж, баялгийн сангуудын ил тод байдал, хариуцлага, засаглалын 24 зарчим бүхий “ Сантьягогийн зарчмууд ”-ыг баталсан.
2009 оны 4 дүгээр сар	Форум байгуулагдсан	Сантьягогийн зарчмуудыг хэрэгжүүлэгч бие даасан байгууллага буюу Форум (IFSWF)-ийг IWG-ийн үргэлжлэл болгон байгуулсан. 2009-2014 онуудад түр хугацаанд ОУВС-аас дэмжлэг аван үйл ажиллагаа явуулж байсан.

2014 он	Бие даасан үйл ажиллагаа	Форум нь ажлын албыг Лондон хотноо төвлөрүүлж, ОУВС-аас тусгаарлагдан үйл ажиллагаа явуулах болов.
2016 он	Гишүүдийн тоо өссөн	30 гаруй баялгийн сангийн гишүүнчлэлтэй болсон.
2018 он	IFSWF Benchmarking эхлүүлсэн	Баялгийн сангуудын засаглал, ил тод байдлыг үнэлэх өөрийн үнэлгээний загвар (self-assessment framework) нэвтрүүлсэн.
2020 он	КОВИД-19 судалгаа	Цар тахлын үед баялгийн сангуудын эдийн засгийн тогтворжуулах үүргийг судалсан онцгой тайлан гаргасан.
2022 он	БОНЗ-д нийцсэн хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлт болон БОНЗ чиглэлд баялгийн сангуудын бодлого, хөрөнгө оруулалтын хандлагын талаар тусгай судалгаа хийсэн.

4.2 Гишүүнчлэл

Форумын гишүүнчлэлийн 2 түвшинтэй бөгөөд одоогоор 38 ҮБС-гууд бүрэн эрхт гишүүн⁴, 5 ҮБС нь харилцагч гишүүний статустай байна. 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдөр АНУ-ын Аляска мужид зохион байгуулсан Форумын жилийн уулзалтын үеэр Монгол Улсын Ирээдүйн өв санг “Харилцагч гишүүн”-ээр элссэн тухай зарласан байдаг⁵. Гэсэн хэдий Ирээдүйн өв сангийн мэдээлэл Форумын харилцагч гишүүдийн жагсаалтад байхгүй байгаагаас үзэхэд өнөөдрийн байдлаар харилцагч гишүүний статус хүчинтэй эсэх нь тодорхой бус, гишүүнчлэлийн статусыг баталгаажуулах шаардлагатай гэж дүгнэхэд хүргэж байна.⁶

Хүснэгт 6. Форумын гишүүнчлэл

Гишүүнчлэл	Шалгуур	Гишүүний давуу тал
Бүрэн эрхт гишүүн (full membership)	• Гишүүнчлэлийн төлбөр төлдөг Сангийн удирддаг хөрөнгөөс хамаарч гишүүнчлэлийн төлбөр төлдөг. 2022 онд Форумын гишүүнчлэлийн төлбөр \$1.1 саяд хүрсэн нь гишүүдийн тоонд хуваавал жилийн гишүүнчлэлийн төлбөр 30 мянган доллар болон түүнээс өндөр байх магадлалтай байна⁷.	Нэр хүнд – Баялгийн сангийн сайн засаглал, Сантьягогийн зарчмуудыг бүрэн хэрэгжүүлдэг гэдгээр олон улсын тавцанд итгэл хүлээдэг. Оролцоо – Удирдах зөвлөлд оролцох, бодлого тодорхойлоход шууд оролцох эрхтэй. Нийтэд танигдах байдал – Форумын вебсайт болон олон улсын тайлангуудад бүрэн бүртгэгддэг. Ил тод байдлын нотолгоо – Сангийнхаа тайлан, удирдлага, хяналтын бүтцийг нээлттэй

⁴ [Олон улсын үндэсний баялгийн сангуудын форумын вебсайт](#)

⁵ [Олон улсын үндэсний баялгийн сангуудын форумын мэдээ](#), 2019 он

⁶ ЗТБТЧУ-ний 2025 оны тайлан

⁷ [Global SFW.com вебсайт](#)

	• Сантьяго зарчмуудыг бүрэн хэрэгжүүлсэн байх Харилцагч гишүүнээр элсэн тодорхой хугацааны дараа Сантьяго зарчмуудыг үйл ажиллагаандаа бүрэн мөрдлөг болгосон тухайгаа нотолж, нэмэлт ярилцлага хийж, Форумын Удирдах зөвлөлөөр баталгаажсаны үндсэн дээр “бүрэн эрхт” гишүүн болдог.	болгодог тул хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээдэг. Хөтөлбөр, сургалтанд хамрагдах эрх – Форумын санал болгодог академик, бодлогын семинар, гишүүн харилцан мэдлэг солилцох зэрэгт тэргүүлэх байдлаар оролцох.
Харилцагч гишүүн (associate membership)	• Гишүүнчлэлийн төлбөр төлдөггүй. • Шинэ байгуулагдсан, өөрийн засаглал, ил тод байдлаа хөгжүүлж буй сангуудын эхний алхам буюу шилжилтийн гишүүнчлэл	Саналын эрх байхгүй боловч хэлэлцүүлэг, жилийн арга хэмжээнд оролцох эрхтэй.

Эх сурвалж: Форумын цахим хуудас

Форум анх Үндэсний баялгийн сангийн олон улсын ажлын хэсгийн гишүүн 23 улсын 26 ҮБС-гуудаас гишүүнчлэлээ бүрдүүлэн үйл ажиллагаа явуулж байсан хэдий ч Форумын үүсгэн байгуулахад идэвхтэй оролцож байсан 7 ҮБС-гууд тэр дундаа нийслэлээр нь нэрлэгдсэн Сантьяго зарчмуудыг тунхаглахад оролцсон Чили Улс, дэлхийн хамгийн том ҮБС болон Норвегийн тэтгэврийн сан Форумын гишүүнчлэлээс гарсан байдаг.

Хүснэгт 7.7. Гишүүнчлэлээс гарсан ҮБС-гууд

Улс	ҮБС	Форумаас гарсан шалтгаан	Гарсан он
Чили	Эдийн засаг, нийгмийн тогтворжуулах сан	Гишүүнчлэлийн бүтэц дахин зохион байгуулсан.	2015 он орчим
Канад	Альбертагийн Өв Хуримтлалын Сан	Баялгийн сан биш гэж үзсэн.	2014–2015
Экваторын Гвиней	Ирээдүйн үеийн төлөөх сан	Ил тод байдал муу, удаа дараа бага үнэлгээтэй байсан.	2012–2014
Иран	Газрын тосны тогтворжуулах сан	Засаглалын хувьд бүтцийн томоохон өөрчлөлттэйгээр шинэ сан (Үндэсний хөгжлийн сан нэртэйгээр) байгуулагдсан.	2012 он орчим
Норвеги	Засгийн газрын тэтгэврийн сан (GPFG)	Сангийн яам Форумын үйл ажиллагааг дэмжихээ больсноор	2014 он орчим

		гишүүнчлэлээс албан ёсоор татгалзсан.	
ОХУ	Нөөцийн сан / Үндэсний баялгийн сан	Бүтцийн өөрчлөлт, өөрийн хүсэлтээр гарсан	2014–2016
Сингапур	Темасек Холдинг	Сонгодог утгаар баялгийн сан биш гэж үзсэн учир өөрсдөө гишүүнчлэлээс татгалзсан.	2013 он орчим

Эх үүсвэр: PIIE судалгаа⁸

Одоогийн 38 бүрэн эрхт гишүүн ҮБС-гууд, үүнээс Форумыг үндэслэн байгуулахад оролцсон сангуудыг тодруулж(саарал өнгөөр) Хүснэгт 7-д харуулав.

Хүснэгт 8. Форумын одоогийн гишүүн ҮБС


№	Үндэсний баялгийн сангууд	Улс
Бүрэн эрхт гишүүн (38)		
1	Abu Dhabi Investment Authority (ADIA)	АНЭУ
2	Agaciro Development Fund	Рванда Улс
3	Alaska Permanent Fund	АНУ
4	BpiFrance	Франц Улс
5	Budgetary Income Stabilization Fund	Мексик Улс
6	CDP Equity SpA	Итали Улс
7	China Investment Corporation	БНХАУ
8	Compañía Española de Financiación del Desarrollo	Испани Улс
9	Fondo de Ahorro de Panamá	Панама
10	Fonds Gabonais d'Investissements Stratégiques	Габон
11	Fonds Souverain d'Investissements Stratégiques S.A.	Сенегал
12	Fundo Soberano de Angola	Ангола
13	Future fund	Австрали
14	Ghana Petroleum Funds	Гана
15	GIC Private Limited	Сингапур
16	Growthfund	Грек
17	Indonesia Investment Authority	Индонез
18	Intergenerational Trust Fund for the People of the Republic of Nauru	Науру
19	Investment Corporation of Dubai	АНЭУ
20	Ireland Strategic Investment Fund	Ирланд
21	Ithmar Capital	Морокко
22	JSC National Investment Corporation of the National Bank of Kazakhstan	Казахстан
23	Khazanah Nasional Berhad	Малайз
24	Korea Investment Corporation	БНСУ
25	Kuwait Investment Authority	Кувейт

⁸ [Peterson Institute for International Economics байгууллагын судалгаа](#)

26	Libyan Investment Authority	Ливи
27	Mubadala Investment Company	АНЭУ
28	New Zealand Superannuation Fund	Шинэ Зеланд
29	Nigeria Sovereign Investment Authority	Нигер Улс
30	Oman Investment Authority	Оман Улс
31	Palestine Investment Fund	Палестин
32	Qatar Investment Authority	Катар
33	State Oil Fund of the Republic of Azerbaijan	Азербайжан
34	The Heritage and Stabilization Fund	Тринидад Табаго
35	The Pula Fund	Ботсвана
36	The Sovereign Fund of Egypt	Египет
37	Timor-Leste Petroleum Fund	Тимор Лесте
38	Türkiye Wealth Fund	Турк Улс
Харилцагч гишүүн (5)		
1	Ethiopian Investment Holdings	Этиопи Улс
2	Fórum de Fundos Soberanos Brasileiros	Бразили Улс
3	Maharlika Investment Corporation	Филиппин Улс
4	National Infrastructure Investment Fund	Энэтхэг Улс
5	Natural Resource Fund	Гуяана

Форумын гишүүнчлэлд гарсан томоохон өөрчлөлтүүдээс тухайлбал Норвегийн тэтгэврийн сан Форумаас гарсантай холбоотой Форумын гишүүн ҮБС-гууд нийт ҮБС-ийн зах зээлийн 2008 онд 75%-ийг удирдаж байсан бол 2025 оны байдлаар 50%-ийг эзлэх болсон байна.

Зураглал 1. Форумын гишүүдийн өөрчлөлт



Эх сурвалж: Үндэсний баялгийн сангуудын судалгааны төв⁹

⁹ Үндэсний баялгийн сангуудын судалгааны төвийн судалгаа, 2025 он

4.3 Форумын жилийн чуулган

Форумын ажлын алба байгуулагдсанаас хойш буюу 2014 оноос эхлэн жил бүр ҮБС-гуудын гишүүн орнуудын хүрээнд жилийн өндөр хэмжээний чуулга уулзалтыг ээлжлэн хариуцаж жил бүрийн 9-11 дүгээр сард зохион байгуулж ирсэн уламжлалтай. 2025 оны уулзалтыг АНЭУ-ын Абу Дабид хийхээр төлөвлөж байгаа мэдээ Форумын вебсайтад байгаа боловч арга хэмжээний урьдчилсан хөтөлбөр, бусад мэдээлэл тодорхойгүй байна.

Хүснэгт 9. Форумын сүүлийн 10 удаагийн жилийн уулзалтууд

Он	Хот, зохион байгуулагч	Сэдэв	Гол үр дүн
2014	Доха, Катар (QIA хариуцав) (IFSWF)	“Domestic and international role of SWFs”	3 жилийн стратеги баталж, Santiago зарчмуудын хэрэгжилтийг дэмжсэн 15 кейс судалгаа нийтэлсэн.
2015	Милан, Итали (Fondo Strategico Italiano хариуцав) (IFSWF)	“Governance, accountability & transparency”	IFSWF-ийн захирлын шинэчлэл Европын дэд бүтцийн хөрөнгө оруулалт хэлэлцсэн.
2016	Окланд, Шинэ Зеланд (NZSF хариуцав) (IFSWF, IFSWF)	“SWFs' response to climate change”	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бодлогын хариу арга хэмжээ тодорхойлсон.
2017	Астана, Казахстан (Samruk-Kazyna хариуцав) (IFSWF)	“Expanding global membership & engagement”	Зүүн Азийн ижил төст хөрөнгө оруулагчидыг татан оролцуулсан болов.
2018	Марракеш, Марокко (Ithmar Capital хариуцав) (IFSWF)	“Scaling governance standards”	Засаглалын өндөр стандартуудыг түгээсэн Peer learning -харилцан туршлага судлах хөтөлбөр, арга хэмжээ нэмэгдсэн.
2019	Жиунау, Аляска муж, АНУ (Alaska Permanent Fund) (IFSWF)	“Peer engagement & knowledge sharing”	Гишүүдийн хооронд мэдээлэл солилцох үйл ажиллагаа эрчимжсэн.
2020	Virtual (COVID-19 нөхцөлд) (IFSWF)	“Continuity in the Face of Upheaval”	КОВИД-19 хямралын үед SWF-үүдийн тогтвортой байдлыг дэмжсэн тайлан гарч, туршлага хуваалцсан.
2022	Баку, Азербайжан (SOFAZ хариуцав) (IFSWF)	“ESG and climate mainstreaming”	Байгаль орчны чиглэлийн цогц судалгаа/стратегийудыг танилцуулсан.

2023	Мадрид, Испани (COFIDES хариуцав) (IFSWF)	“Investing in Transition”	Цахим шилжилт, уур амьсгал, ногоон эрчим хүчний шилжилт, эх үүсвэрүүд рүү хөрөнгө оруулах сэдвүүдийг хөндөв.
2024	Мускат, Оман (Oman Investment Authority хариуцав) (IFSWF)	“Embracing Disruption and Searching for Resilient Futures”	Геополитикийн тодорхойгүй байдал, Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба боломжууд, хөрөнгө оруулалтын стратегид хэрхэн тусгах, Технологийн өөрчлөлт ба хиймэл оюун ухаан (AI)-ы хөрөнгө оруулалтын орчинд авчрах сорилт, боломж, Ил тод байдал ба сайн засаглал, олон улсын стандартуудтай нийцэж ажиллах чиг хандлага зэрэг сэдвүүдийг хөндсөн.

4.4 Сантьяго зарчмуудын тухай

Форумын үндсэн зорилго нь Сантьягогийн зарчмуудыг хэрэгжүүлж, гишүүн болон сонирхогч талуудад түгээж, дэлгэрүүлэн хэрэгжүүлэх замаар баялгийн сангуудын ил тод байдал, хариуцлага, засаглалын чанарыг сайжруулах явдал бөгөөд ҮБС-гуудын олон улсын сайн туршлага, сайн засаглалыг бэхжүүлэх зорилготой Сантьяго зарчмуудыг 3 үндсэн бүлэг агуулгаар авч үздэг. Үүнд:

- Бүлэг 1: Хууль эрх зүйн орчин, зорилго болон макро-эдийн засгийн бодлогоор зохицуулах (Зарчим 1-5)
- Бүлэг 2: Байгууллагын зохион байгуулалт болон засаглалын бүтэц (Зарчим 6-17)
- Бүлэг 3: Хөрөнгө оруулалт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо (Зарчим 18-24).

Монгол Улсын хувьд Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг баталснаар Сантьягогийн зарчмыг хэрэгжүүлж эхэлсэн гэж үзэж болно. 2019 онд батлагдсан Үндэсний баялгийн сангийн тухай хууль нь цаашид төрөлжсөн сангуудын хөрөнгө удирдлагыг хэрэгжүүлэх, засаглалын бүтцийг тодорхойлох, нээлттэй ил тод байдлыг бэхжүүлэх харилцаанд баримтлах гол эрхзүйн зохицуулалт учраас Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг олон улсын жишигт нийцүүлэх зорилгын хүрээнд Сантьяго зарчмуудад бүрэн нийцүүлэхэд эрмэлзэн ажиллах хэрэгцээ, шаардлага байна.

Хүснэгт 10. Сантьяго зарчмууд

Бүлэг	Сантьяго зарчмууд
Хууль эрх зүйн орчин, зорилго болон макро-эдийн засгийн бодлогоор зохицуулах	Зарчим 1: Баялгийн сангийн эрх зүйн орчин нь тодорхой бөгөөд сангийн үйл ажиллагаа үр дүнтэй ба зорилгодоо хүрэхэд дэмжлэг үзүүлэхүйц байх.
	Дэд зарчим 1.1. Баялгийн сангийн эрх зүйн орчин нь Баялгийн сангийн хуулийн зохицуулалт, үйл ажиллагааг эрхлэн явуулахад хангалттай байх.
	Дэд зарчим 1.2. Төрөлжсөн сангуудын онцлог ялгаа, бүтэц, тэдгээрийн хоорондын болон бусад төрийн байгууллагатай харилцах харилцаа нь олон нийтэд ил тод байх.
	Зарчим 2: Баялгийн сангийн бодлого, зорилго нь ойлгомжтой тодорхойлогдсон байх, олон нийтэд ил тод нээлттэй байх.
	Зарчим 3: Баялгийн сангийн үйл ажиллагаа нь дотоодын макро эдийн засагт шууд нөлөөлөх тул баялгийн сангийн үйл ажиллагааг төсөв, мөнгөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас удирдан чиглүүлэх.
	Зарчим 4: Баялгийн сангийн эх үүсвэр, зарцуулалт, санхүүжилт болон зарцуулалтын үйл ажиллагаа нь урьдчилан тодорхойлогдсон нийтэд ил тод бодлого, дүрэм журмаар зохицуулагддаг байх.
	Дэд зарчим 4.1. Баялгийн сангийн санхүүжилтийн эх үүсвэр нь олон нийтэд нээлттэй байх
	Дэд зарчим 4.2. Баялгийн сангаас зарцуулалт хийх ерөнхий чиглэл болон Засгийн газар иргэдийн нэрийн өмнөөс зарцуулалт хийх журам нийтэд ил тод байх
Байгууллагын бүтэц болон засаглалын бүтэц	Зарчим 5: Баялгийн сангийн статистик тоон мэдээллийг цаг тухай бүрд, шаардлагатай бол зохих макро эдийн засгийн үзүүлэлтийн хамт өмчлөгчид тайлагнадаг байх
	Зарчим 6: Баялгийн сангийн засаглалын тогтолцоо, хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг тавьсан зорилгодоо хүрэхэд нь бие даасан байдлаар үйл ажиллагаа явуулахын тулд нэгжийн үүрэг, хариуцлагын тогтолцоо ойлгомжтой, үр ашигтайгаар зохион байгуулагдсан байх.
	Зарчим 7: Баялгийн сангийн өмчлөгч нь баялгийн сангийн зорилго, зорилтыг тодорхойлж, урьдчилсан тогтоосон процедурын дагуу Сангийн удирдах дээд байгууллагыг томилох, үйл ажиллагаанд хяналт тавих.
	Зарчим 8: Баялгийн сангийн дээд удирдах байгууллага нь Баялгийн сангийн эрх ашгийн төлөө сонирхлын зөрчилгүй үйл

	ажиллагаа явуулах ба энэхүү үүргээ биелүүлэхийн тулд хөрөнгийн удирдлагын мандат тодорхой, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хангалттай бүрэн эрх, эрх мэдэлтэй байх.
	Зарчим 9: Баялгийн сангийн үйл ажиллагааны удирдлага нь баялгийн сангийн стратегийг бие даасан байдлаар, урьдчилан тодорхойлсон чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлдэг байх.
	Зарчим 10: Баялгийн сангийн үйл ажиллагааны хариуцлагын тогтолцоо нь холбогдох хууль, дүрэм, хөрөнгийн удирдлагын гэрээнд тодорхой тусгагдсан байх.
	Зарчим 11: Баялгийн сангийн жилийн тайлан, санхүүгийн нь олон улсад ба дотоодод хүлээн зөвшөөрсөн Нягтлан бодох бүртгэлийн стандартад зааснаар төлөвлөсөн хугацаандаа гардаг байх.
	Зарчим 12: Баялгийн сангийн үйл ажиллагаа ба санхүүгийн тайлангууд нь жил бүр олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартын дагуу аудит хийгддэг байх
	Зарчим 13: Мэргэжлийн болон ёс зүйн хэм хэмжээ нь ойлгомжтой тодорхойлогдсон, Баялгийн сангийн удирдах байгууллага болон ажилтнуудын бүх түвшинд хэрэгжүүлдэг байх.
	Зарчим 14: Баялгийн сангийн үйл ажиллагааг удирдан явуулах зорилгоор гуравдагч этгээдтэй харилцах харилцаа нь зөвхөн эдийн засгийн болон санхүүгийн зорилгод суурилсан, цаашлаад дүрэм, журам нь тодорхой байх.
	Зарчим 15: Баялгийн сангийн хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг явуулж буй улс орнуудын зохицуулалт, мэдээллийн ил тод байдлын бүхий л шаардлагыг баялгийн сан хангаж ажилладаг байх.
	Зарчим 16: Баялгийн сангийн засаглалын бүтэц, зорилго хөрөнгийн удирдлагын үйл ажиллагааг бие даасан байдлыг хангахуйц, өмчлөгчөөс хараат бус, олон нийтэд ил тод байх.
Хөрөнгө оруулалт болон эрсдэлийн удирдлагын тогтолцоо	Зарчим 17: Баялгийн сантай холбоотой санхүүгийн мэдээллийг олон нийтэд танилцуулж, эдийн засаг, санхүүгийн чиг баримжааг харуулж, хөрөнгө удирдлагын үйл ажиллагааг явуулж буй улс орны итгэлцлийг нэмэгдүүлдэг байх.
	Зарчим 18: Баялгийн сангийн хөрөнгө оруулалтын бодлого нь багцын зохистой удирдлагын зарчимд суурилсан, зорилго бүхий, хөрөнгө оруулалтын стратеги, эрсдэлийн түвшинд бүрэн тодорхойлогдсон байх.

	Дэд зарчим 18.1. Баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бодлого нь баялгийн сангийн санхүүгийн эрсдэлийн түвшин болон үр өгөөжийн хөшүүргийг хэрэглэх боломжийг тусгасан байх.
	Дэд зарчим 18.2. Баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бодлого нь дотоод болон гадаад хөрөнгө оруулалтын менежерүүдэд зориулагдсан байх ба тэдгээрийн үйл ажиллагааны цар хүрээ, эрх хэмжээ, тэдгээрийг сонгох, гүйцэтгэлд хяналт тавих журмыг тодорхойлсон байх.
	Дэд зарчим 18.3. Баялгийн сангийн хөрөнгө удирдлагын бодлого нь нийтэд ил тод байх.
	Зарчим 19: Баялгийн сангийн хөрөнгө удирдлагын шийдвэр нь хөрөнгө удирдлагын бодлогын дагуу, санхүү эдийн засгийн тооцоолол бүхий, эрсдэлээр жигнэгдсэн өгөөжийг хамгийн их байлгахад чиглэдэг байх
	Дэд зарчим 19.1. Хэрвээ баялгийн сангийн хөрөнгө удирдлагын шийдвэр нь санхүү, эдийн засгийн шинжилгээнээс өөр үндэслэлтэй бол хөрөнгө удирдлагын бодлогод тусгагдсан, олон нийтэд ил тод байх.
	Дэд зарчим 19.2. Баялгийн сангийн хөрөнгийн удирдлага хэрэгжүүлэгч нь нийтээр хүлээн зөвшөөрсөн хөрөнгийн удирдлагын зарчмуудтай нийцсэн, тогтвортой байх.
	Зарчим 20: Баялгийн сан нь хувийн хэвшилтэй өрсөлдөхдөө давуу эрхээр, эсвэл засгийн газрын зохисгүй нөлөөллөөр мэдээлэл олж авахгүй байх, тийм давуу талыг эрэлхийлэхгүй байх.
	Зарчим 21: Баялгийн сан нь хувьцааны саналын эрхийг хөрөнгийн удирдлагын салшгүй хэсэг гэж үзнэ. Хэрэв баялгийн сан нь хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэхээр шийдсэн бол хөрөнгө удирдлагын бодлогод нийцүүлж, хөрөнгө оруулалтынхаа өгөөжийн үнэ цэнийг хамгаалах аргаар хэрэгжүүлнэ. Баялгийн сан нь хувьцаа эзэмшигчийн эрхээ хэрэгжүүлэхдээ биржид бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн үнэт цаасны санал өгөх ерөнхий аргыг үндэслэл болгож, олон нийтэд нээлттэй зарласан байна.
	Зарчим 22: Баялгийн сан нь сангийн үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах суурь тогтолцоотой байх.
	Дэд зарчим 22.1. Баялгийн сангийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь тодорхой хүлээн зөвшөөрөгдөх түвшний дотор

	эрсдэлийг удирдах, хянах, хяналт урамшууллын тогтолцоо, ёс зүйн дүрэм, бизнесийн тасралтгүй байх төлөвлөгөө, бие даасан аудитын үүргийг хангахуйцаар баталгаатай мэдээлэл дээр суурилан, цаг тухай бүр тайлан гаргадаг байх.
	Дэд зарчим 22.2. Баялгийн сангийн эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь нийтэд ил тод байх.
	Зарчим 23: Урьдчилан тодорхойлсон стандарт, зарчмуудын дагуу баялгийн сангийн хөрөнгө удирдлагын гүйцэтгэлийг хэмжиж, өмчлөгчид тайлагнадаг байх.
	Зарчим 24: Баялгийн сан Сантьяго зарчмуудын хэрэгжүүлж буй эсэх талаар тогтмол дүгнэлт гаргадаг байх.

Эх сурвалж: Чингис хаан ҮБС ХХК-ийн судалгаа¹⁰

5. НЭГ ДЭЛХИЙ ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГУУДЫН СҮЛЖЭЭ (ONE PLANET SWF)

5.1 Товч танилцуулга

Нэг дэлхий ҮБС-гуудын сүлжээ (цаашид “Сүлжээ” гэх) нь 2017 оны 12 дугаар сард Франц Улсын Парис хотноо зохион байгуулагдсан “One Planet Summit” арга хэмжээний хүрээнд үүсгэн байгуулагдсан бөгөөд Ерөнхийлөгч Эммануэль Макроны санаачилгаар “ҮБС-гууд хөрөнгө оруулалт дахь цаг уурын өөрчлөлтийн эрсдэл, боломжийг нэн даруй нэгтгэх зорилготой ажилладаг ажлын бүлэг (“One Planet SWF Working Group”) байдлаар эхэлжээ.

Сүлжээ нь уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, түүний эрсдэл, болзошгүй үр нөлөөг улс орнуудын баялгийн удирдлагад тусгах замаар илүү хариуцлагатай, урт хугацааны тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжихэд чиглэсэн хүчирхэг олон улсын платформ болон хөгжиж байна.

Сүлжээ нь дараах зорилгыг тавьж ажиллаж байна. Үүнд:

- Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгийн урсгалыг идэвхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тэр дундаа уур амьсгалын шийдлүүдэд хөрөнгө оруулалт хийх боломжит зах зээлийг хурдацтай өргөжүүлэхэд чиглэн ажиллах;
- Уур амьсгалтай холбоотой санхүүгийн эрсдэл, боломжуудыг урт хугацааны хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд тусгах, нэгтгэх ажлыг түргэсгэх;
- Мэдлэг, туршлага хуваалцахын давуу талыг ашиглахын зэрэгцээ уян хатан, шуурхай байдалд суурилсан хамтын ажиллагааг хадгалах.

Хүснэгт 11. Гол үйл явдлууд

Он	Гол үйл явдал	Үр дүн
----	---------------	--------

¹⁰ [Сантьяго зарчмууд](#)

2017	OPSWF санаачилга Парисын “One Planet Summit” дээр зарлагдав	ҮБС-гууд уур амьсгалын хариуцлагатай хөрөнгө оруулалтад нэгдэх амлалт өгс
2018	OPSWF Framework (3 зарчим, 12 зөвлөмжтэй) батлагдав	Уур амьсгалын эрсдэл, боломжийг хөрөнгө оруулалтад нэгдүүлэх анхны олон улсын удирдамжийг нийтэлсэн.
2019	One Planet Asset Managers (OPAM) санаачилга эхэлсэн	Хөрөнгө удирдлагын компаниудыг хамруулах эхлэл тавигдсан.
2020	OPPEF (Private Equity Funds) санаачилга эхлэв	Хувийн хөрөнгийн сангуудын оролцоог өргөтгөсөн.
2021	4 дэх удаагийн OPSWF Summit зохион байгуулав	Ногоон шилжилтийн стратегид ҮБС-гуудыг татан оролцуулсан
2022	Хамрах хүрээ өргөжиж, нийт 40+ байгууллага нэгдэв	30+ их наяд ам.долларын хөрөнгийг удирддаг ҮБС, хөрөнгийн менежер, хувийн хөрөнгө оруулалтын сангуудын сүлжээ болж өргөжсөн.
2023	6 дахь OPSWF CEO Summit амжилттай болж өнгөрөв	Уур амьсгалд чиглэсэн тайлагнал, хөрөнгө хуваарилалтад ахиц гарсан.
2024	IFSWF-OPSWF хамтарсан "Facing Headwinds" тайлан гаргав	Форумын гишүүн ҮБС-гуудын 75% уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хөрөнгө удирдлагадаа тусгасан болохыг нотолсон.
2025	7 дахь OPSWF Summit Лондонд зохион байгуулав	Уур амьсгалын эрсдэлд тэсвэртэй хөрөнгийн багц бүрдүүлэх шинэ зааварчилгаа танилцуулсан.

Эх сурвалж: Сүлжээний цахим хуудас¹¹

5.2 Гишүүнчлэл

Сүлжээ 2018 онд анх үүсгэн байгуулагдахдаа 6 ҮБС (ADIA, GPFG, KIA, PIF, NZSF, QIA)-гууд 3 жилийн мандаттайгаар эхэлж байсан бол өнөөдрийн байдлаар нийт \$46 их наядын хөрөнгө удирддаг 49 гишүүн буюу 18 ҮБС, 18 хөрөнгө оруулалтын менежментийн компани, 13 хөрөнгө оруулалтын сангийн гишүүнчлэлтэй үйл ажиллагаа явуулж байна. Сүлжээнд элсэхэд “2018 оны суурь зарчмуудаар амласан, уур амьсгалын бодлогыг хөрөнгө оруулалтдаа нэгтгэсэн, ил тод бөгөөд засаглал”-тай байх шаардлага тавигддаг.

- **Сүлжээний зарчмуудыг хэрэгжүүлэх** - 2018 онд батлагдсан тулгуур баримт бичиг болох Alignment, Ownership, Integration зарчмуудыг дагах үүрэгтэй .
- **Уур амьсгалын эрсдэл ба боломжийг хөрөнгө удирдлагад тусгах** - Нарийвчилсан стратеги, явцын тайлан, статистик болон мэдээллийн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай

¹¹ [Сүлжээний вебсайт](#)

- **Парисын хэлэлцээрийн зорилгод нийцсэн хөрөнгө оруулалт хийх** - Хөрөнгө оруулалтыг уур амьсгалд ээлтэй, тогтвортой урт хугацааны үр өгөөжтэй байдлаар чиглүүлсэн байх.
- **Мэдлэг хуваалцах сүлжээнд идэвхтэй оролцох** - Гишүүн байгууллагууд дэд ажлын бүлгүүдэд (OPAM, OPPEF¹² зэрэг) оролцох, семинар, судалгаанд тогтмол орохыг шаарддаг.
- **Хууль, засаглал, ил тод байдлын зарчмуудыг дагах** - Засаглал, ил тод тайлагналт, аудит, тулгуур үзүүлэлтүүдийг мөрдөж байх шаардлагатай.

Хүснэгт 12. Сүлжээний гишүүн ҮБС

№	ҮБС	Улс
1	Norges Bank Investment Management	Норвеги
2	Abu Dhabi Investment Authority (ADIA)	АНЭУ
3	Kuwait Investment Authority (KIA)	Кувейт
4	New Zealand Superannuation Fund (NZSF)	Шинэ Зеланд
5	Public Investment Fund (PIF)	Саудын Араб
6	Qatar Investment Authority (QIA)	Катар
7	FONSIS	Сенегал
8	Ireland Strategic Investment Fund (ISIF)	Ирланд
9	Korea Investment Corporation (KIC)	Солонгос
10	Mubadala Investment Company	АНЭУ
11	National Investment and Infrastructure Fund (NIIF)	Энэтхэг
12	National Investment Corporation of the National Bank of Kazakhstan	Казахстан
13	CDP Equity	Итали
14	Bpifrance	Франц
15	COFIDES	Испани
16	Fond Gabonais D'Investissements Strategiques	Габон
17	Growth Fund-National fund of Greece	Грек
18	Nigeria Sovereign Investment Authority	Нигер

Эх сурвалж: Сүлжээний цахим хуудас

5.3 Нэг дэлхий ҮБС-гуудын зарчим

Сүлжээний гишүүн байгууллагууд Парисын хэлэлцээрийн¹³ зорилттой уялдсан, өндөр дүнтэй, урт хугацааны, төрөлжсөн хөрөнгийн удирдлагыг дэмжих зорилгоор өвөрмөц аргачлал (Framework)-ыг боловсруулсан. Энэхүү “OPSWF Framework” аргачлал нь 2018 оны 7 дугаар сард албан ёсоор нээлтээ хийсэн бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн сэдвээр ҮБС-гуудад зориулсан дэлхийн анхны стратегийн баримт бичиг болсон юм. Уг баримт бичиг нь өнөөдөр ч Сүлжээний гишүүн байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлсээр байгаа ба зөвхөн баялгийн

¹² OPAM-One Planet Asset Managers, OPPEF-One Planet Private Equity Firms

¹³ [Монгол Улс Парисын хэлэлцээрт нэгдэж, УИХ-ын 2016 оны 9 дүгээр сарын 9-ны өдрийн чуулганаар соёрхон баталсан. Парисын хэлэлцээрийн тухай товч танилцуулгыг эндээс үзнэ үү.](#)

сангуудаар хязгаарлагдахгүй, тэргүүлэх хувийн хөрөнгө оруулагчид болон хөрөнгийн менежерүүдийг хамарсан өргөн цар хүрээтэй сүлжээнд тулгуур болон үйлчилж байна. Энэхүү аргачлал нь гурван үндсэн зарчимд суурилсан 12 дэд зарчмууд, зөвлөмжийг агуулдаг. Үүнд:

- **Зарчим 1: Уялдаа (alignment)** - Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлуудыг ҮБС-гуудын хөрөнгө оруулалтын хэтийн төлөвтэй уялдсан шийдвэр гаргах үйл явцад тусгах.
- **Зарчим 2: Эзэмшигчийн үүрэг (ownership)** - Компанийн засаглал, бизнесийн стратеги ба төлөвлөлт, эрсдэлийн удирдлага, олон нийтэд зориулсан тайлагнал зэрэгт уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой чухал асуудлуудыг тусгахыг компаниудад уриалах замаар үнэлэмж бүтээхийг дэмжих.
- **Зарчим 3: Нэгтгэл (integration)** - Уур амьсгалын эрсдэл, боломжуудыг хөрөнгө оруулалтын менежментэд системтэйгээр тусган, урт хугацааны хөрөнгө оруулалтын багцын тогтвортой байдлыг сайжруулах.

Энэхүү аргачлал нь хөгжлийн түвшин, хөрөнгийн хэмжээ, хөрөнгө оруулалтын стратеги харилцан адилгүй улс орнууд болон баялгийн сангуудад хэрэглэхүйц байдлаар боловсруулагдсан бөгөөд тус тусын улсын дотоодын хууль, зохицуулалтын хүрээнд хэрэгждэг.

Хүснэгт 13. Зарчмуудын дэлгэрэнгүй

№	Зарчим	Дэд зарчим	Тайлбар
1	Уялдаа (Alignment)	1.1	Уур амьсгалын өөрчлөлт нь санхүүгийн зах зээлд нөлөөлдөг учир баялгийн сангууд энэ эрсдэлийг төлөвлөх.
		1.2	Уур амьсгалын эрсдэл, боломжийг хөрөнгө оруулалтын бодлогод тусгах.
		1.3	Баялгийн сангууд уур амьсгалын өөрчлөлтийн асуудалд хандах хандлага, үйл ажиллагааг тайлагнаж, ил тод байж, нээлттэй мэдээлэл өгөх.
2	Эзэмшигчийн үүрэг (Ownership)	2.1	ҮБС-гууд хөрөнгө оруулж компаниудын ТУЗ-ийг уур амьсгалд үзүүлж буй нөлөөллөө ойлгож, тодорхой зорилт, стратеги төлөвлөхийг шаардах.
		2.2	Компанийн стратеги, эрсдэлийн менежментэд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой боломжит нөхцөл байдлын хувилбаруудыг тусгах.
		2.3	Уур амьсгалын нөлөөлөлтэй холбоотой мэдээллийг олон нийтэд ил тод нийтлэхийг компаниудад уриалах.
		2.4	Стандартчилагдсан аргачлалаар (Greenhouse gas protocol, Task force on climate-related financial

			disclosures) уур амьсгалтай холбоотой өгөгдлийг тайлагнахыг дэмжих.
3	Нэгтгэл (Integration)	3.1	Хүлэмжийн хийг багасгах эдийн засаг руу шилжих болон бодит уур амьсгалын эрсдэлтэй холбоотой багцын эрсдэлүүдийг тодорхойлох, удирдах.
		3.2	Хөрөнгө оруулалтын хуваарилалт, шийдвэр гаргалтад уур амьсгалын нөхцөл байдлын хувилбарын шинжилгээг ашиглах.
		3.3	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэлхийн хүчин чармайлтаас гарах хөрөнгө оруулалтын шинэ боломжуудыг ашиглах.
		3.4	Уур амьсгалтай холбоотой эрсдэлд өртөх байдал багатай багц бүрдүүлэх стратеги боловсруулах.
		3.5	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой санхүүгийн үр дагаврын талаар судалгаа хийх, дэмжих.

Эх сурвалж: OPFSWF аргачлал¹⁴

5.4 Сүлжээний жилийн чуулга уулзалт

Сүлжээ байгуулагдсан цаг үеэс хойш жилд 1-2 уулзалтуудыг зохион байгуулж, оны дунд үед дунд хугацааны уулзалт, оны эцсээр

Хүснэгт 14. Сүлжээний чуулга уулзалт

Он, Уулзалт	Зохион байгуулагч улс	Гол хэлэлцсэн сэдэв
2017 оны 12 дугаар сар – Нэг дэлхий чуулган	Парис, Франц (Нэг дэлхий чуулганы хүрээнд)	ҮБС-гуудад уур амьсгалын асуудлыг нэгтгэх санаачилга
2018 оны 7 дугаар сар – OPSWF аргачлал боловсруулах ажлын хэсэг	Парис (Elysée Palace)	Climate Alignment буюу Цаг уурын өөрчлөлтийн эсрэг нэгдэх хүрээнд стратеги баталсан
2021 оны 10 дугаар сар – 4th CEO Summit	Парис, Elysée Palace (МАКРОН, КЕРПИ нар оролцох) (static.ie.edu, ifswf.org, kia.gov.kw, global-infra.com)	TCFD ¹⁵ -д дэмжлэг, цаг уурын өөрчлөлттэй холбоотой тайлагнал, харилцан оролцох, цэвэр эрчим хүч
2022 он– 5th CEO Summit & mid-term	Абу Даби (PIF) болон Дублин (ISIF)	Цэвэр устөрөгч (hydrogen), хөрөнгө оруулалтын хэмжүүр, гарч буй зах зээл

¹⁴ “Нэг Дэлхий ҮБС”-гуудын аргачлал

¹⁵ Уур амьсгалтай холбоотой санхүүгийн мэдээллийн ажлын хэсэг (Task Force on Climate-related Financial Disclosures) гэсэн үг юм. Энэхүү ажлын хэсгийг 2015 онд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (G20 дээд хэмжээний уулзалтын үр дүнд байгуулагдсан зөвлөл буюу Financial Stability Board – FSB) байгуулсан бөгөөд байгууллага, хөрөнгө оруулагчдад зориулсан уур амьсгалын эрсдэлтэй холбоотой санхүүгийн мэдээллийг сайн дурын үндсэн дээр ил тод тайлагнах зөвлөмж боловсруулах зорилготой.

2023 оны 6 дугаар сар 6th Summit	Дублин, Ирланд (ISIF)	Аргачлалыг дагаж, hydrogen, climate data, peer-exchange, Emerging Market renewables
2024 он 7th Summit	Рияд, Саудын Араб (PIF)	Hydrogen, Хиймэл оюун, БОНЗ мэдэгдэл, хөгжиж буй зах зээл, байгальд суурилсан шийдлүүд
2025 оны 6 дугаар сар, Дунд хугацааны уулзалт	Лондон, Их Британи (Хамтрагч Qatar Investment Authority, Bloomberg)	Хөрөнгө оруулалтын стратеги, шилжилтийн санхүүжилт, хиймэл оюун), хөгжиж буй зах зээл болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр

Эх сурвалж: Сүлжээний хэвлэлийн мэдээ

6. Нэмэлт судалгаа: ҮНДЭСНИЙ БАЯЛГИЙН САНГУУДЫН СУДАЛГААНЫ ТӨВ (GLOBAL SWF, Global Sovereign Reserve Network GSRN)

6.1 Товч танилцуулга

Үндэсний баялгийн сангуудын судалгааны төв (цаашид “Төв” гэх) 2018 онд байгуулагдсан улс орнуудын “төрийн өмчит хөрөнгө оруулагч” нар буюу ҮБС, Төв банкууд, улсын тэтгэврийн сангуудын үйл ажиллагаа, стратеги, удирдлага, хөрөнгө удирдлагыг ойлгомжтой, хүртээмжтэй мэдээлэх зорилготой платформ (www.globalswf.com)-ыг ажиллуулдаг хувийн судалгааны байгууллага юм.

Тус төвийн үндсэн үйл ажиллагаа нь:

- Зөвлөх үйлчилгээ: ижил төрлийн байгууллагуудын харьцуулалт, хөрөнгө оруулалтыг дэмжих, зөвлөмж өгдөг.
- Мэдээлэл ба судалгаа шинжилгээ буюу төрийн өмчит хөрөнгө удирдагчдын цаг үеийн шинэлэг мэдээлэл, өгөгдөл дата, судалгаа шинжилгээг нийтэлдэг платформ ажиллуулдаг.
- ҮБС-гуудын академи буюу ҮБС-гуудын удирдах түвшний мэргэжилтнүүдийг хамруулсан сургалт явуулах зэрэгт төвлөрч ажилладаг.

Хүснэгт 15. Төвийн гол түүхэн үйл явдал

Он	Гол үйл явдал
2018	Үүсгэн байгуулагдсан; дата платформ, сургалт, консалтинг эхлүүлсэн
2020	GSR Scoreboard-ийг анх нэвтрүүлсэн
2022	Валютын нөөцийн болон баялгийн сангийн хөрөнгө удирдлагын сайн туршлагыг хуваалцах, институц хоорондын харилцааг дэмжих зорилготой GSRN байгуулав.
2024	GSR явцын тусгай тайлан гарч, хөгжиж буй зах зээл, сангуудын ахиц тодорхой мэдээлэх болсон.
2025	GSR-ийн 6 дахь хувилбар гарч, матрикс, аргачлалын шинэ өөрчлөлтүүдийг нэвтрүүлсэн.

Эх үүсвэр: Төвийн вебсайт

Тус Төвийн ажиллуулдаг мэдээллийн платформыг ашиглахад “бүрэн эрхтэй” нэг жилийн \$24 мянган доллар, “хязгаарлалттай” \$10 мянган долларын үнэтэй байдаг.

Төвийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж буй Диего Лопез (Diego Lopez) нь Global SWF байгууллагын үүсгэн байгуулагч бөгөөд Нью-Йорк болон Сингапурт төвтэй ажилладаг. Тэрбээр Үндэсний баялгийн сан (SWF)-гийн чиглэлээр судлаач, зөвлөхөөр PwC, KPMG, Santander банк зэрэг байгууллагуудад ажиллаж байсан туршлагатай.

6.2 Засаглал, Тогтвортой байдал ба Тэсвэрлэх чадварын үнэлгээ (Governance, Sustainability and Resilience - GSR-Scoreboard)

Төвөөс салбарлан байгуулагдсан Global Sovereign Reserve Network¹⁶-оос гаргадаг “Засаглал, Тогтвортой байдал ба Тэсвэрлэх чадварын үнэлгээ (ЗТБТЧҮ)” нь ҮБС-гууд, улсын тэтгэврийн сангуудын засаглал, тогтвортой хөгжил, стратегийн тэсвэртэй байдлыг харьцуулж үнэлэх анхдагч олон улсын бенчмарк үнэлгээ бөгөөд Төвөөс 2020 онд санаачилж эхлүүлсэн юм. Энэхүү үнэлгээ гаргах болсон шалтгаан нь 2008 оны дэлхийн нийтийг хамарсан санхүүгийн хямрал (Засаглал), 2015 оны уур амьсгалын өөрчлөлтийг чухалчлах болсон (Тогтвортой байдал), 2020 оны КОВИД-19 цар тахал дэлгэрч (Тэсвэрлэх чадвар) байсан зэрэг үйл явдал энэхүү үнэлгээг бий болоход нөлөөлсөн гэж үздэг.

ЗТБТЧҮ нь дэлхийн дахины ҮБС-гууд болон улсын тэтгэврийн сангуудын зөвхөн олон нийтэд нээлттэй мэдээлэлд суурилан нийт 25 ялгаатай боловч ижил жинтэй үзүүлэлтээс бүрдсэн, үзүүлэлт тус бүр “Тийм” эсвэл “Үгүй” гэсэн 2 сонголттойгоор үнэлж, нийт гарсан оноогоо 100 хувьд шилжүүлэн үнэлдэг аргачлал юм. Тус үнэлгээг дэлхийн томоохон 200 ҮБС болон улсын тэтгэврийн санг хамруулан жил бүрийн 7 дугаар сард олон нийтэд нээлттэй зарладаг. Тус үзүүлэлтийн нэр хүнд өсөн нэмэгдэж, ҮБС-гууд тайлан, вебсайтад нийтлэх улмаар салбарын судалгаанд олноор дурдагдах болсон байна.¹⁷

Хүснэгт 16. Үнэлгээ

Бүлэг	Үзүүлэлт
G-Governance (Засаглал)-10 Сангийн ил тод байдал, удирдлагын бүтэц, хариуцлагын тогтолцоо	<u>Бүтэц</u> 1. Алсын хараа, Эрхэм зорилго 2. Санхүүжилт, зарцуулалтын дүрэм 3. Дотоод ба гадаад засаглал
	<u>Үйл ажиллагаа:</u> 4. Үйл ажиллагааны бүдүүвч, мэдээлэл 5. Гаднын хөрөнгө удирдлага хэрэгжүүлэгчийн мэдээлэл, нэр хүнд

¹⁶ Тус үнэлгээг тооцоолон гаргадаг GSRN байгууллагын хувьд Төвөөс 2022 онд салбарласан байгууллага бөгөөд гишүүнчлэлийн төлбөргүй, ЗТБТЧ үнэлгээний мэдээллийг www.globalsfw.com цахим хуудсаар дамжуулан нийтэлдэг.

¹⁷ [ЗТБТЧҮ-ний 2025 оны тайлан](#)

S – Sustainability (Тогтвортой байдал)-10 Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, засаглал (ESG)	6. Аудитлагдсан тайлан
	<u>Ил тод байдал:</u> 7. Хөрөнгө удирдлагын стратеги, шалгуур 8. Хөрөнгийн багцийн мэдээлэл 9. Удирддаг хөрөнгийн хэмжээ 10. Жилийн өгөөжийн түвшин
	<u>Бодлого:</u> 11. БОНЗ-ын эрсдэлийн удирдлага хэрэгжүүлдэг эсэх 12. Тогтвортой хөгжлийг хангах баг ажилладаг эсэх 13. Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн байдал
	<u>Үйлдэл:</u> 14. Хамруулах, хасах бодлого 15. Хөгжиж буй зах зээлийн хөрөнгө удирдлага хэрэгжүүлэгч 16. Нүүрстөрөгчийн 0 ялгаруулах (net zero emission) амлалт хэрэгжүүлдэг эсэх 17. Эдийн засаг, нийгмийн зорилт
R – Resilience (Тэсвэрлэх чадвар)-5 Урт хугацааны хөрөнгө оруулалтын уян хатан байдал, эрсдэлд тэсвэртэй байдал	<u>Тайлагнал:</u> 18. Стратегийн баримт бичиг мөрдсөн эсэх 19. Тогтвортой хөгжлийн тайлан 20. Эдийн засгийн гол шалгуур үзүүлэлт өгсөн эсэх
	<u>Хууль ёсны байдал:</u> 21. Зарцуулалтын дүрэм, бодлоготой эсэх 22. Эрсдэлийн удирдлагын бодлоготой эсэх
	<u>Дасан зохицох чадвар:</u> 23. Хөрөнгийн багц бүрдүүлэлтийн бодлого, стратеги 24. Хямралын үеийн менежмент 25. Хурд, сахилга бат

Тус Төвөөс энэ оны 7 дугаар сард нийтэлсэн 2025 оны ЗТБТЧҮ-ний тайланд Монгол Улсын Ирээдүйн өв сан нь 12% үнэлгээтэй буюу жагсаалтын **73 дугаар** байранд жагссан байна.

Эзлэсэн байр	Удирддаг хөрөнгө тэрбум \$	ЗТБТЧҮ хувь	Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээ (S&P/Fitch, Moody's үнэлгээний дундаж)	СРІ-Авилгалын индекс	FN-Рэх чөлөөний индекс
73-Монгол Улс	1	12%	28%	33%	84%

7. Нэмэлт судалгаа: ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН (INTERNATIONAL MONETARY FUND - IMF)

7.1 Товч танилцуулга

Олон улсын валютын сан (цаашид “ОУВС” гэх) нь 1944 онд байгуулагдсан, дэлхийн 191 улс орныг гишүүнчлэл бүхий санхүүгийн байгууллага бөгөөд, гишүүн орнуудын эдийн засгийг дэмжих бодлого хэрэгжүүлэх болон мөнгөний бодлогын зөвлөмж өгөх, чадавхыг бэхжүүлэх техникийн туслалцаа үзүүлэх, зээл болон бусад санхүүгийн дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Үндэсний баялгийн сангуудын (цаашид “ҮБС” гэх) олон улсын санхүүгийн зах зээл дэх нөлөө нэмэгдэхтэй зэрэгцэн буюу ипотекийн зээлийн хямралын улмаас их хэмжээний алдагдал хүлээгээд байсан буюу АНУ болон Европын банкуудад нийт \$40 тэрбум гаруй хөрөнгө оруулсан¹⁸ 2007 оны эцэс үеэс хөрөнгийн зах зээл, бодлого боловсруулагчид, үндэсний хууль тогтоогчид болон хэвлэл мэдээллийн ихээхэн анхаарлыг татаж эхэлсэн. ОУВС нь ҮБС-уудын олон улсын санхүүгийн зах зээл дэх ач холбогдол өсөн нэмэгдэж байгааг хүлээн зөвшөөрч, мөн гишүүн орнуудын эдийн засаг болон дэлхийн санхүүгийн тогтолцооны эрүүл мэндийг хянах үүргээ биелүүлэх хүрээнд хэдэн хэдэн томоохон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байдаг.

Хүснэгт 17. ОУВС-аас ҮБС-гуудтай холбоотой авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээ, он цагийн дарааллаар

Түүхэн товчоон	Тайлбар
2007 оны 10 дугаар сарын 20-ны өдөр	ОУВС-ын Сайд нарын Зөвлөх Байгууллага болох <i>Олон Улсын Мөнгө, Санхүүгийн Хороо (IMFC)</i> нь ОУВС-д хандан ҮБС-уудын удирдлагын шилдэг туршлагаудын зөвлөмж боловсруулах зорилгоор улс орнуудтай харилцан яриа өрнүүлэхийг уриалав.
2007 оны 11 дүгээр сарын 15–16	ОУВС Вашингтон хотноо “Үндэсний хөрөнгө болон нөөц удирдагчдын дугуй ширээний уулзалт” -ыг анх удаа зохион байгуулж, 28 орны төв банк, сангийн яам, баялгийн сангийн төлөөлөгчдийг оролцуулсан. Энэ нь ҮБС-уудтай бодлого, институц, үйл ажиллагааны асуудлаар албан ёсны яриа хэлэлцээг эхлүүлсэн түүхэн мөч болсон.
2008 оны 4-р сарын 30 – 5-р сарын 1	Үндэсний баялгийн сангийн олон улсын ажлын хэсэг (IWG-SWF) ОУВС-ын зохицуулалтаар байгуулагдсан. Уг бүлэгт 26 орон багтаж, Сантьягогийн зарчмуудыг боловсруулах ажлыг эхлүүлсэн.
2008 оны 10-р сарын 11	IWG-SWF нь ОУВС-ын дэмжлэгтэйгээр Сантьягогийн зарчмууд (нийт 24 зарчим) нэртэй баримт бичгийг албан ёсоор нийтэлсэн. Сантьяго зарчмууд нь баялгийн сангуудын ил тод байдал, засаглал, хариуцлагын тухай дэлхийн жишиг болсон.

¹⁸ [ОУВС-ийн судалгаа, 2008 он](#)

2009 оны 2 дугаар сарын 18–19	Хоёр дахь дугуй ширээний уулзалт зохиогдож, оролцогч орны тоо 32 болж нэмэгдсэн. Уулзалт нь дэлхийн санхүүгийн хямралын үед баялгийн сангууд ба нөөцийн удирдлагын асуудлыг онцолж хэлэлцсэн.
2009 оны 4 дүгээр сар	Сантьягогийн зарчмуудыг хэрэгжүүлэх зорилгоор Олон Улсын Үндэсний Баялгийн Сангийн Форум (IFSWF) байгуулагдсан. ОУВС энэ байгууллагыг үүсэн байгуулагдсан эхэн үед идэвхтэй дэмжиж, үүсгэн байгуулахад оролцож, эхний жилүүдэд техникийн болон зохион байгуулалтын түвшинд дэмжиж, тусгай дэд данс (Subaccount) байгуулан, хурлууд зохион байгуулах, тайлан гаргах, гишүүнчлэл хөгжүүлэх зэрэг туслалцаа үзүүлж байв.
2009-2014 онуудад	ОУВС-ын форумын ажлын алба ОУВС-ын төв байранд байрлаж, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлж, ОУВС тус форумын гишүүн орнуудын гишүүнчлэлийн төлбөрөөс үйл ажиллагааны зардлын 7%-ийг удирдлагын шимтгэл болгон авч байв.
2014 оноос хойш	ОУВС нь “Founding sponsor” буюу олон улсын форумын зөвлөх, дэмжигч байгууллага хэлбэрээр оролцох болж, форум бие даан Лондонд төвтэйгээр үйл ажиллагаагаа явуулах болсон. ОУВС нь ҮБС-гуудын засаглал, хөрөнгө оруулалтын бодлого, эрсдлийн удирдлагын чиглэлд онолын болон практик зөвлөмж, техникийн туслалцаа үргэлжлүүлэн үзүүлж байна.

Эх сурвалж: ОУВС хэвлэлийн мэдээ

7.2 Гол ажлууд

Мөн ОУВС-аас баялгийн сангуудтай холбоотой судалгаа нийтлэлүүд нь Сантьяго зарчмуудаас эхлүүлэн боловсруулж, баялгийн сангуудын институцийн бодлого, хөрөнгө удирдлага, засаглал, макро орчны эрсдлийн удирдлага, макро бодлогын үр нөлөөг шинжилсэн арга зүйн хүрээнд тасралтгүй үргэлжилсээр байна.

Хүснэгт 18. ОУВС-аас ҮБС холбоотой гаргасан сэдэвт судалгаа, нийтлэл

Он	Судалгааны гарчиг	Гол агуулга
2008 оны 2 дугаар сар	<i>Sovereign Wealth Funds – A Work Agenda</i>	ҮБС-үүдйн ач холбогдлыг онцолж, төрийн өмчийн хөрөнгө удирдлагын хүрээнд бодлогын төлөвлөгөөг танилцуулсан.
2008 оны 11 дүгээр сар	<i>SWF: Institutional & Operational Practices</i>	ҮБС-уудын институцийн, үйл ажиллагааны туршлагыг судалж, төрөлжүүлсэн онцлогийг тайлбарласан.
2009 оны 8 дугаар сар	<i>Setting Up a Sovereign Wealth Fund</i>	ҮБС байгуулах бодлого, үйл ажиллагааны алхмуудын чиглэлийг санал болгосон практик гарын авлага.
2011 оны 11 дүгээр сар	<i>Investment Objectives of SWFs</i>	Хөрөнгө удирдлагын зорилго, стратеги, макро орчны эрсдлийн үнэлгээний загвар, хямралын дараах нөхцөл байдалд хөрвөх чадварыг үнэлсэн.

2013 (11 сар)	<i>Aspects of Governance Structures and Investment management</i>	Засаглалын бүтэц, хөрөнгө оруулалтын мандат, эрсдлийн зохицуулалт, хяналт, ил тод байдлын зарчмуудыг системийн хэмжээнд авч үзсэн.
2018 оны 2 дугаар сар	<i>Commodity-based SWFs: Managing Financial Flows</i>	Байгалийн баялгийн сангуудын макро санхүүгийн холболтын талаар тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийсэн.
2023 оны 6 дугаар сар	<i>Do SWFs Reduce Fiscal Policy Pro-cyclicality?</i>	182 орны 1980–2019 оны дүнд суурилад УБС-уудын макро бодлого тогтворжуулах үүргийг судалжээ.

Эх сурвалж: ОУВС-ын мэдээллийн сан